

BUILDING TRUST



СИКА МОНГОЛИА ХХК-ИЙН
“СОНСГОЛОН-БЕТОН ЗУУРМАГИЙН
НЭМЭЛТ БОДИС ИМПОРТЛОХ,
АШИГЛАХ, ХАДГАЛАХ АГУУЛАХ”
ТӨСЛИЙН БОМТ-2024”
БИЕЛЭЛТИЙН
ТАЙЛАН

Байршил: УБ хот, Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо

2024 он

АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	3
1.1 ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
2 ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ.....	6
2.1 ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ХУРААНГУЙ.....	7
2.2 БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ.....	7
2.3 ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ.....	ERROR! BOOKMARK NOT DEFINED.
2.4 ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНД БОЛОН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ	ERROR! BOOKMARK NOT DEFINED.
2.5 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЗӨВЛӨМЖ.....	ERROR! BOOKMARK NOT DEFINED.
2.6 ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ	ERROR! BOOKMARK NOT DEFINED.
2.7 СОНГОЛОН-ТҮҮХИЙ ЭДИЙН АГУУЛАХЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ.....	22
3 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	16
3.1 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ	16
3.2 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	18
3.3 ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	23
3.4 ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	31
3.5 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	32
3.6 ХОГ ХАЯГДАЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	32
3.7 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	57
3.8 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	59
3.9 Нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах хөтөлбөр	38
3.10 2022 онд хийгдсэн байгаль орчны аудитын зөвлөмжид тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө	38
4 ДҮГНЭЛТ	40
5 ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ	67

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА


1.1 Төслийн товч танилцуулга

Төслийн нэр:	Бетоны нэмэлтийн агуулах
Төсөл хэрэгжүүлэгч:	“Сика Монголиа” ХХК
Улсын бүртгэлийн дугаар:	9019071038
Регистрийн дугаар:	5641683
Хаяг:	Компанийн төв оффис нь УБ хот, СБД, 1-хороо, Ландмарк товер 502 тоотод байрладаг
Холбоо барих утас:	+976 7013-1360; +976-8806-0467

Сика Монголиа ХХК нь Швейцар улсын Sika® AG групп компанийн 76 дахь салбар охин компани болж 2012 онд үүсгэн байгуулагдсан. Бид үүсгэн байгуулагдсан цагаасаа өнөөг хүртэл Сика брэндийн бетоны нэмэлтийг Монгол орны эрс тэс уур амьсгалд зориулан бүтээгдэхүүний хөгжүүлэлтийг тогтмол хийж байгаа бөгөөд бүтээгдэхүүний нэр төрөл, сонголтыг нэмэгдүүлж, хэрэглэгчийн хүсэлт, шаардлагын дагуу байнгын сайжруулалт хийж ажилласаар байна.

Sika® бренд нь тусгай зориулалтын химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч бөгөөд барилгын салбарт бетоны нэмэлт, ус чийг тусгаарлах, дээвэр, шал, заадас, чигжээс болон холбоос, бүтээцийн хүчитгэгч болон авто машин үйлдвэрлэлийн салбарт барьцалдуулагч, чигжээс, ус чийг тусгаарлагч, хүчитгэгч, гадаргуу хамгаалах зориулалт бүхий нэмэлт бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлдвэрлэлийн систем хөгжүүлэлтийн чиглэлээр дэлхийд тэргүүлэх үйлдвэрлэгч юм.

Sika® бренд нь анх 1910 онд үүсгэн байгуулсан бөгөөд 2024 оны жилийн эцсийн байдлаар дэлхийн 103 гаруй улсад өөрийн салбар компанитай, нийт 400 гаруй үйлдвэр, агуулах, туршилт судалгааны төвөөр дамжуулан бүтээгдэхүүн хөгжүүлэлт, үйлдвэрлэл, түгээлтийг хийж байгаа бөгөөд 33000 гаруй ажилтантай болоод байна.



Зураг 1. Sika® AG группийн бүс нутгийн салбарууд

Сика Монголиа ХХК нь хэрэглэгч, харилцагч нартаа чанартай, техникийн шаардлага хангасан бүтээгдэхүүн нийлүүлэх үүднээс бүх бүтээгдэхүүнээ тохирлын гэрчилгээжүүлж, баталгаажуулсан. Мөн 2021 оноос менежментийн тогтолцооны ISO 9001 - Чанарын Удирдлагын Тогтолцоо, ISO 45001 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцооны стандартыг нэвтрүүлсэн бөгөөд 2023 онд тус хоёр стандартын магадлан итгэмжлэлд дахин хамрагдаж, амжилттай сунгасан.

Төслийн байршил

Төслийн байршил: “Сика монголиа” ХХК-ийн “Бетон зуурмагийн нэмэлт бодис импортлох, ашиглах, хадгалах агуулах” төсөл нь Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутагт, Иргэн Ж. Энх-Отгоны 1.4 га талбайд үйл ажиллагаа явуулна.

Уг төслийн байршил нь ДЦС-4 -ийн баруун тал, цахилгаан станцийн үнс зайлуулах талбайн зүүн талд, Туул голын баруун эргээс хойд зүгт 1.5-3.1 км зайд, УБ хотын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс, тэжээгдлийн мужийн гадна, мөн Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалт, эрүүл ахуйн бүсийн гадна, Сонгинохайрхан дүүргийн үйлдвэрлэлийн бүсэд оршино.



Зураг. 1. Төслийн талбайн байршлын зураг

Химийн бодисын агуулах

Тус агуулахын байр нь 2023 онд ашиглалтад орсон, төмөр карказан бүтэцтэй, сендвичэн хийцтэй 624м² талбай бүхий объект байна. Тус агуулахыг “Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүн агуулах” ерөнхий шаардлага MNS 6458:2014 болон Аж ахуй нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм MNS 5566 : 2020 стандартуудын шаардлагад нийцүүлэн галын хор, галын сарайн иж бүрдэл, утаа мэдрэгч, галын гар мэдээлэгч, шугаман утаа мэдрэгч, хяналтын камер, GSM дамжуулагч, галын булан, ослын гэрэлтүүлэг, галын аюулгүй байдлын самбар, тэмдэг, тэмдэглэгээг байршуулан, 24 цагийн камерийн нэгдсэн систем, гэрээт харуул хамгаалалттайгаар ашиглаж байна.

Дотороо 20м² бүхий ажилчдын амралт, анхны тусламжийн өрөө болон камерийн хяналтын 2ш тусдаа өрөөтэй, шаардлагатай зүйлсээр тоноглож, тохижуулсан.



Зураг 3. “Сика Монголиа” ХХК-ийн түүхий эдийн агуулахын гадна, дотор тал

Тус бетоны нэмэлтийн түүхий эдийн агуулахад 2-3 нэр төрлийн хуурай түүхий эдийг бүтээгдэхүүний зориулалт, хэрэглээ, тоо хэмжээ, техникийн шаардлага, бүтээгдэхүүн худалдан авалт нийлүүлэлт, цаг хугацаа, улирал гэх мэт олон хүчин зүйлийг үндэслэн импортлон оруулж ирж, нөөцлөн хадгалж байна.


Барилгын бусад бараа материалын ихэнх төрөл нь хадгалалтын хугацаа богино тул хэрэглэгчийн хүсэлт, захиалгын дагуу импортлон, нийлүүлдэг.



Зураг 1-10. Сонсголон-Түүхий эдийн агуулахын дотор тал

Сика Монголиа ХХК нь Сонсголон-Бетоны нэмэлтийн агуулах нь галын аюулгүй байдлын шаардлагыг бүрэн хангаж Галын дүгнэлтийг Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтэсээс авсан.

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Сика Монголиа” ХХК-ийн БЕТОН ЗУУРМАГИЙН НЭМЭЛТ БОДИС ИМПОРТЛОХ, АШИГЛАХ, ХАДГАЛАХ, ХАДГАЛАХ АГУУЛАХ төслийн 2024 оны БОМТ – БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН




Зураг 1-11. Сонсгolon-Түүхий эдийн агуулахын гал унтраах шуурхай төлөвлөгөө болон галын дүгнэлт

2 ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

“Сика Монголиа” ХХК нь тус "Бетон зуурмагийн нэмэлт бодис импортлох ашиглах хадгалах агуулах" төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж болох болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг нарийвчлан тогтоох зорилгоор Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг 2024 оны 5-р сард “Хас цас” ХХК-аар хийлгүүлсэн болно.

Сонсгolon агуулах нь Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт байрлана. Тус агуулахын эзэмшил зам талбай нь бүрэн хатуу хучилттай бөгөөд хүний нөлөөлөлд өртсөн байгалийн унаган төрхөө хэдийн алдсан газар юм.

Төслийн талбай нь байгалийн бүс бүслүүрийн ангилалаар ойт хээрийн бүсийн ангилалд багтаж байна.



Зураг. 4. Байгалийн бүс бүслүүр

2.1 Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн хураангуй

Энэхүү агуулахын үйл ажиллагааны үед байгаль орчны төлөв байдал, орон нутгийн нийгэм эдийн засагт нөлөөлж болох нөлөөллүүдийн хэлбэр, тэр нь эргэж нөлөөлөх, буцалтгүй нөлөөлөх эсэхийг болон гол нөлөөллийн үргэлжлэх хугацаа, түүний эрчимшил зэргийг тодруулахын тулд магадлан жагсаах аргыг хэрэглэв.

2.2 Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, үнэлгээний арга зүй

Энэхүү БОМТ-г боловсруулахдаа Монгол Улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, БОАЖ-ын Сайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А-618 дугаар тушаалын баталсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” зэргийг удирдлага болголоо. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг матрицын аргаар хийж гүйцэтгэв.

3.2. Гол сөрөг нөлөөлөл

Дээр өгүүлсэн болзошгүй нөлөөллийн судалгааны үр дүнгээс үзвэл төслийн үйл ажиллагааны явцад газрын гадаргуу, хөрс, агаар бохирдох зэрэг нөлөөллүүд нь аюулгүй ажиллагааны дүрэм журмыг баримтлаагүйгээс үүсэх нөлөөллүүд байна.

Голлох нөлөөллийг тодорхойлохдоо:

1. Гарч болох бохирдлын түвшинг харгалзан үзэх
2. Сөрөг нөлөөллийн үр дагаврыг бууруулах арга замыг эрж хайхад шаардлагатай мэдээллийг бүрдүүлэх

3. Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх арга замын талаар зөвлөмж боловсруулж өгөх явдал юм.

Энэ зорилгоор байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болон тээвэрлэлтийн үе шатууд дахь нөлөөллийн эрчмийг үнэлсэн экспертүүдийн үнэлгээгээр матриц байгуулах аргыг өргөн ашигладаг. Энэ аргын нэг хувилбар нь Леопольдын матриц юм. Бид энд Леопольдын матрицыг химийн бодисыг тээвэрлэлт, хадгалалтын процесс явагдах үеийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээний ажилд зориулан бага зэрэг хувиргасан байдлаар ашигласан болно. Үүний тулд байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд (агаар, хөрс, ус, ургамал, амьтан г.м)-ийн чухам ямар үе шатанд нь илүү их нөлөөлөлд өртөж байгаа тухай экспертүүдийн үнэлгээг үндэс болгон тогтоолоо.

Леопольдын матрицын аргаар дүгнэж үзэхэд Бетон зуурмагийн нэмэлт бодис импортлох ашиглах хадгалах агуулах төслийн үйл ажиллагааны үе шатуудаас эдийн засаг, ажиллагсдын эрүүл мэндэд хамгийн их нөлөөлөл үзүүлэхээр байна. Газар доорх ус, газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамалан нөмрөгт үзүүлэх нөлөө их биш ч бодис асгарсан тохиолдолд газрын гадарга, хөрсөн бүрхэвч болон газар доорх усанд маш хүчтэй сөрөг нөлөөлөл үзүүлэхээр байна.

Эдгээр нөлөөллийг бууруулах, үүсэхгүй байх боломжтой бөгөөд төслийн үйл ажиллагааны үед үүсэх гол нөлөөллийг химийн бодисын асгаралт, алдагдалаас үүсэх аюул байна гэж үзлээ. Ингээд энэ нөлөөллийн талаар эрсдлийн үнэлгээний хэсэгт аргачлалын дагуу тусгайлан тооцож үнэлсэн болно.

Хүснэгт 4. Төслийн голлох сөрөг нөлөөлөл

Эх үүсвэр	Хөрс	Агаар	Эдэлбэр газар
Химийн түүхий эдийн сав, боодлын хаягдал	Химийн бодисын хаягдал сав, боодлын хаягдал		
Агуулах орчны тоосжилт		Бодис тээвэрлэх явцад агаарт тоосжилт үүснэ.	
Ахуйн хог хаягдал үүсэх	Хог хаягдлын судалгаанаас үзвэл өдөрт 1.5 кг, 1 жилийн хугацаанд 370.5кг ахуйн хатуу хог хаягдал гарах болно.		
Төслөөс үзүүлэх дуу чимээ		Агуулахын дотоод агаар орчинд дуу чимээний тархалт үүснэ.	

3.2.1. Газрын гадрага, хэвлийд нөлөөлөх гол ба болзошгүй нөлөөлөл

Бетон зуурмагийн нэмэлт бодис импортлох ашиглах хадгалах агуулах төслийн үйл ажиллагаа нь хөрсний элэгдэл, бохирдолд шууд нөлөөлөх ба төслөөс бий болох аюултай болон хатуу хаягдлыг задгай хаягдлын цэг байгуулснаас болон хогийн цэгийг ариутгаагүй удах, хогийг зохих график хуваарийн дагуу ачихгүй байх зэрэг шалтгаанаас хөрс бохирдох, мөн химийн гаралтай бодисыг тээвэрлэлтийн үед алдаж асгах тохиолдолд газрын гадарга бохирдох зэргээр сөрөг нөлөөлөл гарах эрсдэлтэй байна.

Гол сөрөг нөлөөлөл

Хүснэгт 5. Төслөөс газрын гадаргад нөлөөлөх байдал үнэлгээ

НӨЛӨӨЛӨЛ	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ			
	Бага	Дунд	Их	Онц Аюултай
Ахуйн хог хаягдлыг тогтоосон цэгээс өөр газарт хаяж, хөрс бохирдуулах	x			
Химийн бодисыг зөөж тээвэрлэх үед санамсаргүй асгарч хаягдах		x		
Тээвэрлэлтээс тоосжилт үүсэх	x			

Нийт нөлөөлийн агуулахаас хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөлөх нөлөөллийг “БАГА” гэж үзлээ.

Тус Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны нутагт хэрэгжих Бетон зуурмагийн нэмэлт бодис импортлох ашиглах хадгалах агуулах төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга болон хэвлийд нөлөөлөх нөлөөлөл бага зэрэг сөрөг нөлөөлөлтэй байна.

3.2.2. Уур амьсгалд нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Бетон зуурмагийн нэмэлт бодис импортлох ашиглах хадгалах агуулах төслийн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэрийн уур амьсгалд шууд нөлөөлөхгүй. Харин байгалийн аюултай үзэгдлүүд, хүчтэй салхи, шороон шуурга, бороо, үер зэрэг уур амьсгалын хүчин зүйлсээс Бетон зуурмагийн нэмэлт бодис импортлох ашиглах хадгалах агуулах төслийн үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй.

3.2.3. Агаарын чанарт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Төслийн онцлогоос шалтгаалан химийн бодис орчинд алдагдах, агаартай харилцан урвалд орж болзошгүй бөгөөд уг эрсдэлийг энэхүү тайлангийн хүний эрүүл мэнд болон экологийн өртөлтийн үнэлгээнд дэлгэрэнгүй авч үзсэн.

Хүснэгт 6. Төслөөс агаарын чанарт нөлөөлөх байдал, үнэлгээ

НӨЛӨӨЛӨЛ	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ			
	Бага	Дунд	Их	Онц Аюултай
Химийн бодисыг хадгалах үед агуулахад химийн бодис уурших дотоод агаарын бохирдол үүсэх	х			
Ажилчдын эрүүл мэндэд нөлөөлөх		х		
Агуулахын дотоод орчиноос гадагш агаарын бохирдол алдагдах	х			
Химийн бодисыг зөөж тээвэрлэх болон агуулахаас ачих, буулгах тээврийн хэрэгслээс ялгарах утаа орчинд нөлөөлөх			х	
Нийт нөлөөлийн агаарын чанарт нөлөөлөх нөлөөллийг “БАГА” гэж үзлээ.				

3.2.4. Гадаргын болон газрын доорхи усанд нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Төсөл хэрэгжих талбайн ойр орчимд гадаргын ус байхгүй байна. Харин төсөл хэрэгжүүлэгч химийн бодисоо болгоомжгүй байдлаасаа болж асгавал хөрсөнд нэвчсэн бодис гүний усанд нөлөөлнө.

Хүснэгт 7. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн эрчмийн үнэлгээ

№	Сөрөг нөлөөлөл	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ			
		Бага	Дунд	Их	Хүчтэй
1	Төслийн үйл ажиллагаагаар гадаргын усан сүлжээ өөрчлөгдөх	х			
2	Агуулахын үйл ажиллагааны улмаас газрын доорх усны нөөцөд нөлөө үзүүлэх		х		
3	Газар доорхи усны баланс алдагдах, химийн найрлага нь өөрчлөгдөж бохирдох		х		
4	Төслийн үйл ажиллагаанаас гарах ахуйн болон үйлдвэрийн хог хаягдал нь газрын доорх усны чанарт сөрөг нөлөө үзүүлэх		х		

Нийт нөлөөллийн усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл ДУНД зэргийн нөлөөлөл үзүүлэхийг харуулж байна.

3.2.5. Хөрсөн бүрхэвчид нөлөөлөх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл

Төсөл хэрэгжих талбайд ахуйн болон агуулахын хог хаягдлыг зориулалтын дагуу хогын цэгт хаяхгүй ил задгай хаяснаас болж химийн бодис хөрсөнд нэвчих амьтад хортох элдэв өвчин тусах зэрэг сөрөг нөлөөллүүд бий болно.

Хүснэгт 8. Хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийн эрчмийн үнэлгээ

№	Нөлөөлөл	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ			
		Бага	Дунд	Их	Хүчтэй
1	Агуулахын үйл ажиллагааны нөлөөнд үржил шимт хөрс бүхий талбай өртөх	х	-	-	-
2	Агуулахын үйл ажиллагааны үед ахуйн гаралтай хаягдал, химийн бүтээгдэхүүний хаягдлаар хөрсөн бүрхэвч бохирдох	-	х	-	-
3	Хөрсний шимт бодисын нөөц хомсдох, хөрсний гадаргын ургамал бүрхэц сийрэгжсэнээр хөрс эвдрэх үйл явц түргэсгэх	х	-	-	-
4	Хөрсний хими, физик, геохими, биохимийн хөдлөл зүйн горим өөрчлөгдөх	х	-	-	-
5	Хөрс хуурайшиж, бүтэц нь алдагдаж, элэгдэх, механик үйлчлэлээр талхлагдаж сийрэгжих, нимгэрэх	х	-	-	-
6	Хог ургамалд баригдах, доройтох, ахуйн хогоор бохирдох,	-	х	-	-

Нийт нөлөөллийн хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөлөл БАГА байгааг харуулж байна.

3.2.6. Ургамлан нөмрөгт нөлөөлөх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл

Ургамлан бүрхэвч нь мал болон зэрлэг амьтны тэжээл төдийгүй хөрсний дээд давхаргын дулаан ба чийгийг зохицуулагч, хөрс үүсгэгч, бэхжүүлэгч экосистемийн хамгийн гол бүрэлдэхүүн хэсэг юм. Ургамал нөмрөгийн талхагдал дунд зэрэг буй энэ орчимд хүн болоод машин техникийн нөлөөтэй учраас талхагдалд орсон.

Ургамлан нөмрөгийн шууд бус нөлөөлөлд өртөх хэсгийг хүн машин байнга зорчихгүй боловч талхлах, агаараар дамжуулан бохирдол зөөгдөх талбайн хэмжээгээр бүс үүсгэн тогтоосон ба энэ хэсэгт хөрс сүвэрхэгжиж, ус хадгалах чанар болон хуваарилалтад илүү их өөрчлөлт гарч ургамал ургах нөхцөл нь доройтсоноор экосистемийн хуурайших үйл явц эрчимжиж, унаган ургамал үгүй болж бусад хүмүүнсэг ургамлаар солигдох болон ургамлын тусгагийн бүрхцийн бууралт ажиглагдана.

Төслийн үйл ажиллагаанаас ургамлан бүрхэвчинд үзүүлэх нөлөөлөл нь бодис тээвэрлэлт үед асгарах алдагдах эрсдэл бий болж болох бөгөөд үүнээс үүдэн ургамал талхлагдах, устах эрсдэл бий болох магадлалтай.

Хүснэгт 9. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийн эрчмийн үнэлгээ

№	Сөрөг нөлөөлөл	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ			
		Бага	Дунд	Их	Хүчтэй
1	Агуулахын үйл ажиллагааны нөлөөнд үржил шимт хөрс бүхий талбай өртөж ургамлан нөмрөгийн байгалийн унаган төрх алдагдах	х			
2	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний үед гарах тоосоор тодорхой талбайн ургамал дарагдах		х		
3	Ашиглалтад өртөх талбайн ургамлан нөмрөг бүхэлдээ устаж үгүй болно	х			

4	Тээврийн хэрэгслийн нөлөөгөөр ургамлан нөмрөг тоосонд дарагдах	х			
Нийт нөлөөллийн ургамалд үзүүлэх сөрөг нөлөөлөл БАГА байгааг харуулж байна.					

3.2.7. Амьтны аймагт нөлөөлөх гол болон болзошгүй сөрөг нөлөө

Тус Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутагт “Сика Монголиа” ХХК-ийн хэрэгжүүлж буй төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт нөлөөлөх сөрөг нөлөөлөл байхгүй болно.

3.2.8. Нийгмийн эрүүл мэндэд нөлөөлөх гол болон болзошгүй сөрөг нөлөө

Зориулалтын хувцас, хэрэгслийг стандарт шаардлагын дагуу хэрэглэхэд төслийн үйл ажиллагаанаас хүний эрүүл мэндэд шууд сөргөөр нөлөөлөх хүчин зүйл байхгүй болно.

3.3 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

“Сика монголиа” ХХК-ийн төслийн бетон зуурмагийн нэмэлт бодис импортлох хадгалах ашиглах агуулахын үйл ажиллагааны явцад гарч болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, химийн бодис, материалыг байгаль орчин, экологид хор хөнөөлгүйгээр хадгалах болон тэдгээрийг хамгийн бага сөрөг нөлөөлөлтэйгээр хадгалах, зөөвөрлөх, устгах, зайлуулах, нөхөн сэргээх замаар тухайн орон нутгийн байгалийн өнгө төрх, хэлбэр, хор аюулгүй нөхцөлд орон нутгийн хүн ам, амьтан ургамал, үржин төлжих нөхцөлийг бүрдүүлэхэд төслийн үйл ажиллагааны гол зорилго оршино. Иймд төслийн болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

3.3.1. Цаг уур, уур амьсгалаас үзүүлэх нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ

Химийн бодисуудын хадгалалт, тээвэрлэлтийн үед цаг агаарын болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэхийн тулд хадгалж буй агуулах нь доор дурдсан шаардлагуудыг хангасан байх ёстой. Үүнд:

- Химийн бодисын агуулахын агааржуулалтын системийн ажиллагаа, агааржуулалтын хоолойн бүрэн бүтэн байдал, химийн бодисын савны болон асгарсан бодис тарахаас сэргийлсэн тосгуур, суурины зузаан, идэгдэлт, химийн бодис тавьсан тавиур болон холбоосны механик бүрэн бүтэн байдал, тавиур дээр хадгалж буй бодисын дээд хэмжээг байнгын хяналт тавихаас гадна шатамхай, онцгой хортой бодисын сав баглаа боодлыг тогтмол хугацааны давтамжтайгаар хийж, тэмдэглэл хөтөлж байх.
- Химийн бодисын агуулахын ажлын байр нь галд тэсвэршилтийн зэргийг хангахуйц материал, хийцтэй, болзошгүй ослын үед хөрсөнд болон гадагш бодис алдагдахааргүй шал (цементэн болон плитан), бат бэх хамгаалалт бүхий цонх, хаалгатай байхаар засаж тохижуулах.
- Химийн бодисын агуулахад хор аюулын лавлах мэдээлэлд тусгасны дагуу хоорондоо нийцэхгүй бодисуудыг хамт хадгалахгүй байх.
- Бүх химийн бодисыг халаалтын хэрэгсэл, цахилгааны эх үүсвэр, системээс хол, шууд нарны гэрэл тусахааргүй нөхцөлд хадгалах, барилгад аянга зайлуулагч тавих зэрэг болно.

3.3.2. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ

- Химийн хортой болон аюултай бодисын хадгалалтын болон хадгалах хугацааны горимыг нарийн чанд баримтлах, ялангуяа тодорхой хугацааны дараа уурших, задрах гэх мэтээр бүтэц найрлага нь өөрчлөгддөг тогтвортой биш бодис болон савалгааны материал нь хязгаарлагдмал ашиглалтын хугацаатай химийн бодисыг агуулахад хадгалахад үйлдвэрлэгчээс зааж өгсөн хугацааг хянаж, хуучин бодисыг эхэлж ашиглах зарчмыг баримтлах.
- Химийн бодисын агуулахын хадгалах нөхцлийг стандартын шаардлагын түвшинд тохижуулах, хор аюулын лавлах мэдээлэлд тусгагдсан зааврын дагуу хадгалах, ялангуяа химийн бодисын агуулахад хор аюулын лавлах мэдээлэлд тусгагдсаны дагуу хоорондоо нийцэхгүй бодисуудыг хамт хадгалахгүй байх.
- Агаарын чанарын хяналтын хэмжилт хийх ажилтанг томилох, хавсран гүйцэтгэх тохиолдолд ажил үүргийнх нь хуваарьт оруулах.
- Агуулахын гадаад болон дотоод орчноос ОХШХ-т тусгасан үзүүлэлтээс сорьц авч, мэргэжлийн байгууллагаар шинжилгээ хийлгэж, түвшинг тодорхойлуулан, заавар зөвлөмж авч ажиллах.
- Тээвэрлэлт хийдэг машины хурдны хязгаарлалтыг зааж, асаалттай орхихгүй байх
- Шороо тоос дэгдэхээс урьдчилан сэргийлж, агуулахын гадна талбайн хатуу хучилтыг хагарал гарсан тохиолдолд нөхөх, дулааны улиралд усалгаа хийх.

3.3.3. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ

- Цементэлсэн талбайд хагарал гарсан тохиолдолд тухай бүр нь засварлах.
- Аюултай хог хаягдлыг хадгалах байрыг агуулахаас тусад нь гаргаж шалыг хатуу хучилттай болгох.
- Химийн бодис, аюултай хог хаягдлын хадгалалтад тавих хяналтыг тогтмол байхаар ажиллагсдын ажил үүргийн хуваарьт тусгаж, ажлын график гарган мөрдүүлэх.
- Химийн бодисын агуулахын барилга байгууламж нь шалыг химийн үйлчлэлд тэсвэртэй зузаан материалаар хийсэн боловч нэвчилт, алдагдлыг байнга шалгаж, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч байх.
- Тээвэрлэлт, хадгалалтын үйл ажиллагааг шаардлагын дагуу зөв явуулах, химийн бодисыг хөрсөнд алдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг байнга авч хэрэгжүүлэх.
- Химийн бодисын агуулахын ажлын байр нь тухайн бодисын хор аюулын лавлах мэдээлэлд заасан шингээгч материалаар (зориулалтын шингээгч, хуурай элс, тогтворжуулагч, үртэс гэх мэт) хангагдсан байна. Химийн бодис асгарах, алдагдах үед ашиглах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хоосон сав, бортого, бортого онгойлгогч, наалддаг шошго, металл юүлүүр, хүрз, хогийн шүүр, хориглох тэмдэг болон тууз зэрэг багаж хэрэгслээр хангагдсан байх зэрэг болно.
- Хөрсөн орчныг хамгаалах, нөлөөллийг бууруулах арга хэмжээ нь ургамал, амьтан, усны нөөцийг хамгаалах үйл ажиллагаатай нягт уялдаатай юм. Цаашид төв замаас төслийн талбайн хашааны гаднах зам хүртэл талбайд мод бут тарьснаар тухайн орчинд бичил био орчин үүсэж, төслийн үйл ажиллагаанаас үүсэж болзошгүй газрын гадарга, хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөллийг саармагжуулах боломжтой.

3.3.4. Усны чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ

- Химийн бодисын тээвэрлэлт, хадгалалтыг хор аюулын лавлах мэдээлэлд тусгасны дагуу явуулах, усан орчинд нөлөөлөл үзүүлэхээс урьдчилан сэргийлэх
- Химийн бодисын агуулахад химийн бодис, бүтээгдэхүүнийг татан авчрах, хүлээн авах үйл ажиллагааг явуулахдаа хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангах ажиллах зэрэг болно.

3.3.5. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ

- Химийн бодисын аюулгүй ажиллагаа, түүнийг зөрчсөнтэй холбоотой осол аваар нь голдуу химийн бодис зөөвөрлөх машин, техникийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааны горим алдагдсанаас үүдэлтэй байдаг. Химийн хортой болон аюултай бодисыг тээвэрлэх болон устгах үеийн аюулгүй ажиллагаа зөрчигдсөнөөс болон ургамлан нөмрөг, ургамалжилтад үзүүлэх сөрөг нөлөөлөл илүү байна. Иймээс химийн бодис тээвэрлэх, хадгалах журамд заагдсаны дагуу алдаж асгахаас сэргийлэх арга хэмжээ авах хэрэгтэй.
- Төслийн талбайн ашиглагдаагүй хэсэгт мод бут, зүлэг ногоо тарих.

3.3.6. Хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ

- Химийн бодисын агуулахын ажиллагсад бодистой ажиллах болон асгарсан бодисыг саармагжуулах, хурааж авах зэрэг үйл ажиллагааны явцад хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэлгүй ажиллах зэрэг тохиолдолд бодист түлэгдэх, бодисын уураар амьсгалах, хордох зэрэг эрсдэл үүсч болзошгүй тул хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг сайтар ханган ажиллах.
- Химийн бодисын агуулахын барилгын хийц, инженерийн байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийн доголдоос үүдэн аюул, осол гарахаас байнга урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, агуулахын бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавих.
- Химийн бодисын агуулахад ажиллаж буй мэргэжилтэн нь хор аюулын лавлах мэдээлэлд заасан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангаж ажиллахаас гадна химийн бодис алдагдахаас урьдчилан сэргийлсэн бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх, асгарч алдагдсан тохиолдолд түүнийг саармагжуулах арга хэмжээг авах чадварыг эзэмшсэн байх.
- Аюулгүй ажиллагааны зааварчилгааг өөрийн байгууллагын даргаар батлуулан ажлын байр болон агуулахад химийн бодистой харьцаж ажилладаг ажилтан өдөр тутмын ажиллагаанд ашиглаж байх боломжтой харагдахуйц газарт байрлуулах бөгөөд аюулгүй ажиллагааны зааварчилгаанд химийн бодисын хор аюул, үүсэж болох эрсдэл /хүний эрүүл мэнд, байгаль орчин/, химийн бодистой харьцах, хадгалах зааварчилгаа, асгарч алдагдсан болон галын аюулын үед авах арга хэмжээ, анхны тусламж, хувийн хамгаалах хэрэгсэл, хэрэглэх заавар, хаягдлыг устгах зааварчилгааг зэргийг багтаасан байна.
- Химийн хорт болон аюултай бодис тээвэрлэх, хадгалахтай холбоотой үйл ажиллагааг хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны нөхцөл, шаардлагыг бүрэн хангасан зориулалтын байр, талбайд явуулахаас гадна болзошгүй аюул, осол гарсан үед хүний эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчинд үүсэх хохирлыг бууруулах зорилгоор авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа, түүний дарааллыг тогтоосон “Аюул, ослын үед ажиллах төлөвлөгөө” боловсруулж, тухайн орон нутгийн Онцгой байдлын газраар батлуулсан

хэрэгжүүлэх.

- Химийн бодистой харьцаж ажилладаг ажиллагсдыг үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнийг хянах, эрсдэл үүссэн тохиолдолд хариу арга хэмжээ авах мэдлэг, дадлыг эзэмшүүлэх сургалтад заавал хамруулсан байх.
- Химийн бодисын агуулахын болзошгүй аюул, ослын үед ашиглах, хор аюулын лавлах мэдээлэлд заасны дагуу бүрэн ажиллагаатай гал унтраах багаж, хэрэгсэл, хор саармагжуулах бодис, уусмал, химийн бодис асгарч алдагдсан үед ашиглах багаж, хэрэгсэл, шингээгч материал, хувийн хамгаалах хэрэгсэл (арьс, нүд, амьсгал хамгаалах), амьсгал хамгаалах баг, нүд угаах болон ослын шүршүүр зэргийг ажлын байранд байршуулж, тэдгээрийн бүрэн бүтэн байдал, хэвийн ажиллагааг тогтмол шалгаж байх, ажиллагсдад ажиллах дадлыг эзэмшүүлэх.
- Химийн бодисын агуулахад утаа мэдрэгч, галын дохиоллын систем, даралт мэдрэгч болон тэсрэлт үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хий зайлуулагч автомат төхөөрөмж суурилуулах зэрэг болно.

3.3.7. Химийн бодис материал алдагдсан үед авах арга хэмжээ, зөвлөмж

“Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам”-ын 2.1.2-д химийн бодистой ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгааг үйлдвэрлэгчээс гаргасан ХАЛМ-д үндэслэн боловсруулж өөрийн байгууллагын даргаар батлуулсан байх ёстой хэмээн заасан байдаг. Мөн журмын 2.1.5-д болзошгүй аюул, ослын үед авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа, төлөвлөгөө боловсруулж, тухайн орон нутгийн онцгой байдлын газраар батлуулсан байна хэмээн заасан байдаг.

Тус химийн бодисын агуулахын үйл ажиллагааг эхлэхээс өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа, аюул ослын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөж батлуулах шаардлагатай байна. Аюул ослын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөж боловсруулахад дараах зөвлөмжүүдийг тусгах хэрэгтэй. Үүнд:

- Их хэмжээгээр ус, хөрсөнд алдагдсан тохиолдолд “Орон нутгийн онцгой байдлын алба”-нд мэдээлэл яаралтай хүргэж, тархах хүрээг хумих боломжит арга хэмжээг авч, рН-ийг өсгөх, саармагжуулах зорилгоор шингээж авахаар модны үртэс дээр нь нэмнэ.
- Бодис материалууд их хэмжээгээр ус, хөрсөнд алдагдсан тохиолдолд “орон нутгийн онцгой байдлын алба”-нд мэдээлэл яаралтай хүргэж, дээрхи аргуудаар осол аюулын зэрэглэлийг бууруулах шаардлагатай бөгөөд аюул ослын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар холбогдох байгууллагуудад тайлагнах шаардлагатай.

3.3.8. Химийн бодисын хаягдлыг хадгалах, тогтворжуулах зөвлөмж

Төсөлд химийн бодисыг импортлохдоо түүхий эдийн савыг дахин ашиглах тул энэ төрлийн хаягдлууд үйл ажиллагааны явцад гарахгүй боловч химийн бодисын сав баглаа боодол задрах, ашиглалтын шаардлага хангахгүй болсон тохиолдолд химийн бодисын болон химийн бодис агуулсан сав баглаа боодлын хаягдал гарах магадлалтай. Иймд химийн бодисын хаягдлыг түр хадгалах цэг байгуулан 1м³ багтаамжтай хоосон саванд битүүмжлэн түр хадгалж “Химийн хортой аюултай хаягдлыг устгах, боловсруулах, булшлах байгууламж”-д нийлүүлэх шаардлагатай.

3.3.9. Удирдлага, зохион байгуулалтын талаар

“Химийн хортой болон аюултай бодисын тухай” Монгол улсын хууль Химийн хортой болон аюултай бодисыг импортлох, экспортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх худалдах журам, Химийн хортой болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх ашиглах устгах журам, зэрэг хууль, журам тогтоол дүрэм зэргийг нарийн баримталж ажиллах.

Тусгай зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага химийн хортой болон аюултай бодис худалдахдаа худалдан авсан этгээдийн хаяг, бодисын нэр, төрөл, хэмжээ, ашиглах зориулалтыг заасан баримтыг 2 хувь үйлдэн баталгаажуулж нэг хувийг худалдан авагчид, үлдсэн хувийг өөртөө хадгална.

Химийн хорт болон аюултай бодисыг худалдахдаа худалдан авагчид тухайн бодисын хор, аюулгүй ажиллагааны лавлах мэдээллийг заавал дагалдуулан өгнө.

Хадгалж байгаа химийн хорт болон аюултай бодис нь зориулалтын сав баглаа боодолтой байх, тухайн бодисын сав баглаа боодол нь тухайн бодисын нэр, анхааруулах тэмдэг аюулын шинж чанарыг тод, томоор бичсэн шошготой байна.

Химийн бодисын ашиглалт, зарцуулалтын тайланг БОАЖЯ-нд жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор гаргаж өгнө.

3.3.9.1. Орчныг бохирдлоос хамгаалах талаар

- Үйлдвэрлэгчээс гаргасан хор аюулын лавлах мэдээллийг үндэслэн бодис нэг бүрээр боловруулсан аюулгүй ажиллагааны зааварчилгааг байгаль орчны болон гамшгаас урьдчилан сэргийлэх хяналтын улсын байцаагчаар хянуулж, өөрийн байгууллагын даргаар баталгаажуулсан байна.
- Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах үйл ажиллагаатай холбоотойгоор гарч болзошгүй ослын үед ажиллах төлөвлөгөө боловруулж, аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсээр батлуулсан байна.
- Харилцагч байгууллагуудаас химийн бодисын захиалга авахдаа тэдгээрийн нэр төрөл, тоо хэмжээг нарийн тодорхойлж аль болох борлуулалтаас үлдэгдэл гарч агуулахад хадгалагдахгүй байхаар зохион байгуулах.
- Импортоор оруулан авчрах химийн бодис, материал нэг бүрийн хими, физикийн шинж чанар, хор аюулын зэрэг, тээвэрлэлт, хадгалалтын онцлог нөхцлийн талаар нарийн тээвэрлэх, захиалагч байгууллагад нийлүүлэх, агуулахад хадгалах үйл ажиллагааны үед удирдлага болгох.
- Химийн бодис, материалыг тээвэрлэхдээ зохих байгууллагаас зөвшөөрөл авч шаардлага хангасан сав, баглаа боодолтой, хагарч асгарч гэмтэхээргүй зөөлөвч жийрэгтэйгээр, нийтэд сэрэмжлүүлсэн таних тэмдэг, анхааруулсан тод бичигтэйгээр зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.
- Химийн онцгой хортой бодисын санамсаргүй алдагдал гарсан тохиолдолд хорыг саармагжуулах, ариутгал цэвэрлэгээ хийх, үлдэгдэл хаягдлыг устгах талаар яаралтай авч хэрэгжүүлэх зааварчлагааг бодис нэг бүрээр гаргаж агуулахын ажиллагсад эзэмшүүлэх.

3.3.9.2. Ажиллагсдын эрүүл ахуйг хамгаалах, хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах талаар

- Химийн хорт болон аюултай бодистой харьцаж ажиллагсдыг бодис бүрийн хор аюулын лавлах мэдээлэл, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, болзошгүй ослын үед ажиллах төлөвлөгөө, асгарч алдагдсан тохиолдолд түүнийг саармагжуулах арга хэмжээний талаар сургалтанд хамруулж, гарын үсэг зуруулсны дараа ажиллуулах ба сургалтанд хамрагдаагүй тохиолдолд химийн бодистой харьцаж ажиллахыг хориглох.

- Агуулахын байрны агаар дахь химийн хор аюултай бодисын агуулга, температур, чийгшил, тоосжилтын түвшин зэрэгт хяналт тавих багаж хэрэгсэлтэй болох арга хэмжээг ойрын үед авах.
- Ажиллагсдад химийн бодис, материалыг ачих, буулгах, зөөх үедээ ажлын тусгай хувцас, техник хэрэгслийг ашиглан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрмийн шаардлагыг нарийн баримтлан ажилладаг дадал зуршлыг хэвшүүлэх.
- Онцгой нөхцлийн үед ашиглах хөдөлмөр хамгааллын тусгай хувцас, багаж, техник хэрэгслийн зохих нөөцийг бүрдүүлэх.
- Ажлын байранд мэргэжлийн хяналт, орчны мониторингын болон эрүүл ахуйн байгууллагаар тухай бүр хяналт хийлгэж, дүгнэлт гаргуулж байх. Өөрөөр хэлбэл ажлын байрын эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллын аттестатчилалд байнга хамрагдаж байх .

3.3.9.3. Сургалт судалгааны талаар

- Тус компаний стратегийн болон ойрын зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн технологийн менежмент (сургалт, сурталчилгаа, орчны хяналт)-ийг хөгжүүлэх, удирдлагын байгаль орчин, эрүүл ахуйн талаарх мэдээллийг сайжруулах.
- Агуулахын ажиллагсдад зориулсан байгаль орчин, үйлдвэрлэлийн экологийн талаар сургалтын хөтөлбөр боловсруулж, мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах.
- Химийн бодис, материалын агуулахын үйл ажиллагааг хэвийн явуулах, аливаа гэмтэл, ослоос урьдчилан сэргийлэх аргын үндэс болсон хөдөлмөр хамгааллын зааварчилгааг тогтмол өгч, мөрдөлтөд нь байнга хяналт тавьж байх.
- Хаягдал, бохирдолд тавих байгаль орчны салбарын олон улсын нормативыг технологийн үйл ажиллагааны дамжлага тус бүр дээр мөрдөж ажиллах, орчны хяналт шинжилгээг жил бүр тогтоосон хугацаанд хийлгэж хэвших.

3 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

3.1 Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний зорилт

“Сика Монголиа” ХХК-ийн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих нутгийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй

эрсдэлийг илрүүлэх, тэдгээрийн үр дагаврыг тогтмол хянах, хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллах үүрэгтэй.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд “Сика Монголиа” ХХК-ийн Бетоны нэмэлтийн үйлдвэр, агуулах төслөөс байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардал, дагаж мөрдөх дүрэм журам, стандартуудыг нэгтгэн үзүүлсэн бөгөөд төсөл хэрэгжүүлэгч үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш жил бүр энэхүү үнэлгээгээр тогтоогдсон гол болон болзошгүй эрсдэл, тэдгээрийг арилгах бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг хянан үзэж, шинэчлэн сайжруулж байх шаардлагатайг онцолсон. Ингэхдээ байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрүүдээс гарч буй үр дагавар, бодит байдалтай уялдуулан улам баяжуулж, сайжруулахыг мөрдлөг болгосон. Мөн төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 11 дүгээр сарын 1-ээс өмнө БОАЖЯ, орон нутгийн засаг захиргааны байгууллага, нутгийн оршин суугчдад танилцуулж, тэднээр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийн хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тусгасан болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нийт 5,750,500 төгрөг буюу ерөн есөн сая нэг зуун хорин нэгэн мянга арван хоёр төгрөгийг зарцуулсан байна.

БОМТ хэрэгжүүлэх арга хэмжээний дагуу хийж гүйцэтгэсэн ажлын зардлын зарцуулалтын хураангуйг хүснэгт 3-1-д харуулав.

Хүснэгт 3-1. БОМТ зардлын хураангуй

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Нийт гарсан зардал /төгрөг/
Сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө	600,000.0
Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	500,000
Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Дотоод зардал
Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1,869,000
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	395,000
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	386,500.0
Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө	2,000,000
Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	-
2022 оны аудитын үр дүнгээс гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө	Дотоод зардал
БОМТ-ний ажлын нийт зардал	5,750,500 төгрөг


3.2 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 3-2 сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, CO₂-ийн ялгаралыг бууруулах

Тус Сонсголон агуулахын төсөл дээр савлах, шилжүүлэн ачих зэрэг процесс хийгдэхгүй, мөн шатаах үйл ажиллагаа явуулдаггүй тул агаар орчинд сөрөг нөлөөгүй. Мөн Сика корпорацийн 2023-2028 онд баримтлах тогтвортой хөгжлийн бодлогын (GRI) дагуу CO₂ ийн ялгаралыг тогтмол бууруулах зорилт тавьж өөрөө явагч сэрээт өргөгчийн үзлэг оношлогоог хийж, шатахуун зарцуулалтын хэмжээг тогтмол хянаж шууд ба шууд бус эрчим хүчний хэрэглээнээс ялгарах CO₂-н хэмжээг тооцоолон эрчим хүчний зарцуулалтийн хэмжээг тогтмол бүртгэлжүүлдэг.

/Хавсралт 1 – Сика Монголиа ХХК-ийн 2024 оны III улирлын Тогтвортой хөгжлийн мэдээ (MIS report) /



2024 оны III улирлын хүлэмжийн хийн ялгаруулалтын тооцоолол

Зураг 3-1.

Химийн бодисын хадгалалтын горим, хэт халалтыг хязгаарлахын тулд нарны шууд тусгалд өртөх агуулахын цонхуудад нарны гэрэл сааруулах сүүн хуулга наасан.



Зураг 3-2. Агуулахын цонхон нарны шууд тусгаарлах сүүн хуулга наасан байдал

Машин механизмын хөдөлгөөний аюулгүй байдал, замын хөдөлгөөнөөс үүсэх тоосжилтыг бууруулах үүднээс үйлдвэрийн төслийн талбайд 10км/ц хурдны хязгаарын тэмдэг, автомашины зогсоолын тэмдэг зэргийг байршуулсан. /Хавсралт 3. Хурдны хязгаарын тэмдэг худалдан авсан баримт – 319,000 төгрөг/



Зураг 3-3. Төслийн талбайн

тэмдэг байрлуулсан байдал

үүдэнд хурдны хязгаарын

Дуу чимээний сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх

Компанийн зүгээс ачаа бараа хүлээн авах, ачих, буулгах ажиллагаа гүйцэтгэж байгаа ажилчдад шаардлагатай ХХХ, тусгай хамгаалах хэрэгслээр бүрэн хангаж ажилладаг. Ажлын байранд хувийн хамгаалах хэрэгслэл хэрэглэх самбар, тэмдэг тэмдэглэгээ, зааварыг ажлын байранд байршуулсан.



Хөрсөн орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх

Уг агуулах нь УБ хотын үйлдвэрийн бүс буюу техноген нөлөөлөлд өртсөн газарт байрлахын зэрэгцээ үйлдвэрийн талбай, зорчих зам нь хатуу хучилттай тул хөрсөн орчинд сөрөг нөлөөгүй.

Агуулахын үйл ажиллагааны явцад ялгарах ахуйн хог хаягдлыг ангилан ялгах зориулалтай хогийн савыг ажлын байруудад байршуулсан, ажилчдад хэрхэн ангилан ялгахыг дотоод сургалтаар заадаг. Агуулахын үйл ажиллагаанд байнгын ажиллагаатай биш тул бүтэн цагаар агуулах дээр ажилладаг ажилтан байхгүй. Тиймээс ахуйн хог хаягдал үүсдэггүй.



Зураг. Агуулахад ангилдаг хогийн сав байрлуулсан байдал

Агуулахад химийн бодистой харьцан ажилладаг ажилчдыг тогтмол сургалтанд хамруулдаг ба агуулахад хадгалж байгаа түүхий эд материал, тэдгээрийн ангилал, асгаралтын үед авах арга хэмжээний зааварчилгаа, асгаралтын үеийн иж бүрдэлийг иж бүрнээр байрлуулсан, тогтмол хяналт тавьж, шалгадаг.



Зураг. Химийн бодисын асгаралтын иж бүрдэл байршуулсан байдал

Амьтан, ургамалд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах

Сика Монголиа ХХК нь “Дэлхийн зэрлэг ан амьтдыг хамгаалах өдөр” буюу 3 сарын 3-ны өдрийг тохиолдуулан НБОГ-тай хамтран Хан-Уул дүүргийн 12 дугаар хорооны нутаг дэвсгэр Биокомбинат орчимд бууж ирсэн буга, гөрөөст идэш тэжээлийн дэмжлэг үзүүлэх биотехникийн арга хэмжээ авч өвс тэжээл тавьж өгөх ажлыг 2024.03.05-нд зохион байгууллаа.



Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх

Ажилчдийн ундын усыг цэвэршүүлэн савласан зөөврийн цэвэр усаар хангаж байна.



Зураг. Цэвэршүүлсэн

ашиглаж байгаа байдал

ундны ус, ус цэвэршүүлэгч

Сика Монголиа ХХК-ийн тус төслийн талбайд ажилчдын ахуйн хэрэглээний усаа зөөврийн усаар хангадаг ба гэрээт байгууллагаар гүйцэтгүүлдэг.



2024 оны 01-р сарын 05

УС НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

Дугаар № 001



Нэг талаас: [5783089] дугаартай гэрчилгээний үндсэн дээр үйл ажиллагаа явуулж буй Монгол Улсын хуулийн этгээд болох Баянгол дүүрэг 4-р хороо Нарны зам гудамж 14-602 тоотод байрлах "Мастертийм" ХХК-ийг төлөөлж захирал Г.Ганболор /цаашид Нийлүүлэгч тал гэх/

Нөгөө талаас: [РД:5641683] дугаартай гэрчилгээний үндсэн дээр үйл ажиллагаа явуулж буй Монгол Улсын хуулийн этгээд болох "Сика Монголиа" ХХК-ийг төлөөлж гүйцэтгэх захирал Жонатон Шарки /цаашид худалдан авагч гэх/ нар дор дурдсан нөхцлүүдийг хэлэлцэн тохиролцож, харилцан зөвшөөрснөөр энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Байршил 1: Хан-Уул дүүргийн 20-р хороо, үйлдвэр ХД-Г гудамж, 111-02 тоотод байрлалтай Бетоны нэмэлтийн үйлдвэр.

Байршил 2: Сонгинохайрхан дүүргийн 20-р хороо, Сонсголон талбай-18132 гудамж, 27 тоотод байрлалтай Бетоны нэмэлтийн түүхий эдийн агуулахыг цэвэр усаар хангах үйл ажиллагааг зохицуулах, төлбөр тооцоо хийх журмыг уг гэрээгээр зохицуулна.

1.2. Усыг сард 30тн гэсэн давтамжтайгаар хүргүүлэн авна.

1.3. Гэрээний үргэлжлэх хугацаа нь 2024 оны 01 сарын 05 өдрөөс 2026 оны 01 сарын 05 өдрийг хүртэл хоёр жилийн хугацаатай байна.

Удирдлага зохион байгуулалтын талаар

Компани нь 2024 оны үйл ажиллагааны зардалын хүрээнд ажилчдад шаардлагатай хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй, галын аюулгүй байдал, химийн бодистой харьцан ажилладаг ажилчдын сургал, шаардлагатай хувийн хамгаалах хэрэгслээр бүрэн хангаж ажиллаж байна.

Нийт: 600,000.0 төгрөгийг сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажилд зарцуулсан байна.

3.3 Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Хүснэгт 3-3 Орчны тохижилт, нөхөн сэргээх төлөвлөгөөний биелэлт

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Биелэлт	Арга хэмжээний цар хэмжээ
1	Орчны өнгө үзэмжийг сайжруулах, тоосжилтыг бууруулах	2024 оны 11 сарын байдлаар нийт 5ш мод тариад байна. Мөн манай байгууллага бүх нийтийн мод тарих үйлсэд гар бие оролцож Тэрбум Мод тарих үндэсний хөдөлгөөнд хувь нэмрээ оруулж байна.	Үйлдвэр

Сика Монголиа ХХК нь МУ-ын Ерөнхийлэгчийн санаачилсан “Тэрбум мод” хөтөлбөр болон Үндэсний мод тарих намрын өдрийг тохиолдуулан 2024 оны 10 сарын 25-нд Сонсголон агуулахын урд талбайд 5ш гацуур мод суулгаж тарьсан.



Зураг. “Тэрбум мод” хөтөлбөр хүрээнд Үндэсний мод тарих өдөр мод тарьсан байдал

Мөн агуулахын урд талбайд зүлэгжүүлэлт, цэцэрлэгжүүлэлт хийх үүднээс хаягдал 200л-ийн төмөр сав (поошиг)-ыг тайрч олон наст зүлэг, болон шар цэцэг тарьсан.



Зураг. Үйлдвэрлэлийн бүсийг моджуулсан, цэцэрлэгжүүлсэн байдал

Нийт:	500,000 төгрөгийг орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөт ажилд зарцуулсан байна.
--------------	--

3.4 Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

Хүснэгт 3-4 Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөөний биелэлт



№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв
	“Сика Монголиа” ХХК-ийн Бетоны нэмэлтийн үйлдвэр, агуулах төслийн бүс нь төв суурины бүс, хүн амын суурьшилт бий болоод удаж байгаа ба энэ хугацаанд ямарваа нэгэн түүх, соёлын дурсгалт зүйлс, эртний олдворууд олдсон тохиолдол байхгүй тул энэ талаар мөн тусгаагүй.

3.5 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө


Хүснэгт 3-5 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Биелэлт	Баримтлах эрх зүйн баримт бичиг

1	<p>Галын багаж хэрэгсэл авч ашиглахад бэлэн байдлаар байрлуулах (амьсгалын нэг бүрийн хамгаалалтын аппарат, галын хор, гал унтраагч, усан шүршүүр, гал унтраах хуурай хэрэгсэл, хөөс, нүүрсхүчлийн хий гэх мэт)</p>	 <p>Зураг 3-38. Галын аюулгүй байдлын самбар, галын сарайн иж бүрдэл байрлуулсан байдал</p>	<p>БОХТ хууль, ХБТ хууль</p>
5	<p>Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн ханган ажиллуулах</p>	<p>Ажилчдад зуны болон өвлийн хөдөлмөр хамгааллын хувцасыг олгосон байна.</p>  <p>Зураг 3-16 . Ажилчдад дөрвөн улирлын ажлын хувцас тавьсан байдал</p>	<p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль</p>
6	<p>Хөдөлмөр хамгаалал, осол, аюулаас урьдчилан сэргийлэх, аваарын үеийн арга хэмжээний зааварчилгааг ажиллагсдад тогтмол өгч байх</p>	<p>Ажил эхлэхийн өмнө хөдөлмөр хамгааллын аюулгүй ажиллагааны зааварчилгаа тогтмол өгдөг. Мөн үйлдвэрлэлийн бүсэд нэвтэрсэн зочид, гэрээт компанийн ажилчидыг тогтмол бүртгэж, үйлдвэрлэлийн бүсийн аюулгүй ажиллагааны журамтай танилцуулдаг.</p>	

		 <p>Зураг 3-17. Аюулгүй ажиллагааны зааварчилгааны дэвтэр болон зочдын бүртгэл, төслийн талбайн аюулгүй ажиллагааны дүрэм, журамтай танилцсан бүртгэл</p>	
7	<p>Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, осол, эрсдэлийн статистик тоон мэдээллийг цуглуулах, тэмдэглэл хөтлөх</p>	<p>2024 оны 11 сарын байдлаар осол эрсдэлгүй ажиллаж байна.</p>  <p>Зураг 3-18. Zero Incident буюу аваар осолгүй ажилласан өдрийн мэдээлэх самбар</p>	
10	<p>Хөдөлмөр хамгаалал, осол, аюулаас урьдчилан сэргийлэх, аваарын үеийн арга хэмжээний зааварчилгааг</p>	<p>Төслийн талбайн аюулгүй ажиллагааны дүрэмийг үйлдвэрийн орох хаалганы дээр байрлуулж нийт ажилчид болон зочид, гэрээт байгууллагын ажилчдад заавал мөрдөх аюулгүй ажиллагааны дүрмийг танилцуулдаг.</p>	



<p>ажиллагсад тогтмол өгч байх буюу Сика группийн ЭМААБО-ы стандартуудыг танилцуулах, дагаж мөрдүүлэх</p>	 <p>Зураг 3-27. “Төслийн талбайн аюулгүй ажиллагааны дүрэм” самбар байрлуулсан байдал</p> <p>2023 онд ХАБЭА-ийн аюулгүй ажиллагааны тэмдэг, тэмдэглэгээ (фосфортдог, соронзтой, энгийн хуулгах, төсөл лист, акрил хавтан гэх мэт дээр), төслийн талбайн аюулгүй ажиллагааны дүрэм шинээр хэвлүүлж төслийн тайлбай, ажлын байранд байршуулсан.</p>	
<p>11 Эмнэлгийн анхны тусламжийн багаж хэрэгсэл, эмийн сан байршуулах, шаардлагатай тохиолдолд шинэчилж байх</p>	 <p>Зураг 3-28. Анхны тусламжийн иж бүрдэлийн хайрцагийг том хайрцагаар сольж, байрлуулсан байдал</p>	

		
	<p>Зураг 3-29. Агуулахын эмнэлгийн анхны тусламжийн хайрцаг болон Анхны тусламж үзүүлэх мэдээллийн самбарыг шинэчлэн байрлуулсан байдал.</p>	
<p>13</p>	<p>Ажлын талбайд “Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ” хийлгэх</p>	<p>Сика Монголиа ХХК нь ажлын байрны сөрөг хүчин зүйлсийг бууруулах, мэргэжлээс шалтгаалах өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, өөрсдийн ажлын байрыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, шаардлагад нийцүүлэх үүднээс ээлжит Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг 2024 оны 03 дугаар сарын 11-12 хооронд үйлдвэр, Сонсголон агуулах, төв оффис гэсэн 3 байршилд хийлгэлээ.</p>

		 <p>Зураг. Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэж байгаа байдал</p> <p>/Хавсралт 9. Хийлгэсэн зардалын баримт - 1,869,000 төгрөг/</p>	
16	<p>Гал түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, галын хорыг байршуулах, галын хорын шалгалтыг тогтмол явуулж хөтлөх</p>	<p>Галын хорны үзлэг шалгалтыг тогтмол хийж, галын хорны тэмдэг, тэмдэглэгээ, шалгасан тэмдэглэл бүхий пайз, лацны тросыг шинэчлэсэн. Мөн үйлдвэрлэлийн бүсэд нэмэлтээр 13ш галын хор худалдан авч байршуулсан.</p>  <p>Before After</p> <p>Зураг 3-36. Галын хорны пайзыг шинэчилсэн байдал</p>	<p>Галын аюулгүй байдлын тухай хууль</p>

		 <p>Зураг 3-37. Үйлдвэрийн байранд 13ш, агуулахад 12ш галын хор нэмэлтээр байрлуулсан байдал.</p>	
17	<p>Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлтийг 2 жил тутамд хийлгэх</p>	<p>2023 онд үйлдвэр болон Сонсголон-Агуулахын байранд галын аюулгүй байдлын дүгнэлтийг харьяа дүүргийн Онцгой байдлын хэлтэсээс авсан.</p>  <p>Зураг 3-39. Үйлдвэр болон Сонсголон-Агуулахын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт шинэчилэн авсан байдал</p>	<p>2017.11.08-ны өдрийн ОБЕГ-ын даргын тушаал</p>
18	<p>Гал команд, эмнэлэг, цагдаагийн шуурхай утасны дугааруудыг барилгын талбайд ил харагдахуйцаар байршуулах</p>	<p>Яаралтай үед хэрэгтэй утасны дугаарыг үйлдвэр, агуулах, төв оффис гэсэн 3 байршилаар гаргаж, гарах хаалганы ойролцоо байршуулсан.</p>	<p>ХАБЭАТ хууль</p>


Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Сика Монголиа” ХХК-ийн БЕТОН ЗУУРМАГИЙН НЭМЭЛТ БОДИС ИМПОРТЛОХ, АШИГЛАХ, ХАДГАЛАХ АГУУЛАХ төслийн 2024 оны БОМТ – БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

		 <p>Зураг 3-40. Онцгой байдлын үеийн утасны жагсаалт шинэчлэн байрлуулсан байдал</p>	
19	<p>Үйл ажиллагааны явцад гарсан их хэмжээний асгаралтын (осол) тоог бүртгэх, хянах</p>	<p>Үйл ажиллагааны явцад их хэмжээний асгаралт тохиолдоогүй.</p>	
20	<p>Гэмтэл, бэртэл үүсгэсэн ослын тоо, ослоос шалтгаалан ажиллаж чадаагүй өдрийн тоог бүртгэх, хянах</p>	<p>Сар бүр нийт ажилчдад Health & Safety report буюу гэмтэл, бэртэлийн тоо, түүнээс үүдсэн ажиллаж чадаагүй өдрийн тоо зэрэг тоон мэдээллийг хүргүүлдэг.</p>  <p>Зураг 3-41. Сар бүрийн Health & Safety report</p>	<p>Сика группийн “Тогтвортой байдлыг тайлагнах удирдамж”</p>
21	<p>Жил тутамд нэг ажилтанд ногдож буй сургалтын дундаж цагийг тооцох, бүртгэх</p>	<p>2024 онд 27 удаагийн 837.4 цагийн сургалтанд нийт 149 хүн хамрагдсан ба нэг хүнд оногдох сургалтын хүн цаг 336 минут буюу 5.6 цаг байна.</p>	<p>Сика группийн “Тогтвортой байдлыг тайлагнах удирдамж”</p>

	<p>Сика монголиа компани нь осол эрсдлийг бууруулах байгаль орчинд хор хөнөөлгүй ажиллах зорилгыг эн тэргүүнд тавьж ажилладаг бөгөөд энэхүү зорилго нь бидэнд өөрийн нэр хүнд брэндийг сурталчилах болон тогтвортой үйл ажиллагаа явуулахад үндсэн суурь болж өгдөг.</p> <p>Тиймээс осол эрсдэлгүй үйл ажиллагаа гэдэг бол бидний ажилын гол зарчим юм. Манай үйлдвэрт голлон учирах эрсдэл химийн бодис алдагдах асгарах болон хадгалалт агуулахтай холбоотой болох нь эрсдлийн үнэлгээний байгууллагуудын удаа дараа хийсэн аудитын явцад илэрсэн бөгөөд бидний зүгээс энэ тал дээрээ илүү анхаарал тавин ажиллаж байна. Төслийн үйлдвэрлэлд үл нийцэх химийн бодисууд байхгүй бөгөөд тогтмол хэрэглэгддэг олон тооны шингэн полимерүүдээс тогтсон холимог бүтээгдэхүүн юм. Энэхүү полимер суурьтай бүтээгдэхүүн бусад бетоны уян налархайжуулагч нэмэлтийн үйлдвэрүүдэд голлон хэрэглэгддэг лигносульфат ба уг түүхий эд нь эрүүл мэнд, байгаль орчинд хоргүй тул давуу талтай юм.</p>
Нийт:	1,869,000 төгрөгийг осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөт ажилд зарцуулсан байна.


3.6 Хог хаягдалын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 3-6 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Биелэлт	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хатуу хог хаягдлаар орчныг бохирдуулахгүй байх, хатуу хог хаягдлыг нэг цэгт бөөгнөрүүлж, УБ нэгдсэн хогийн цэг рүү тээвэрлэх	<p>Тус байршил дээр байнгын ажилтан ажиллахгүй тул ахуйн хог хаягдал гараагүй байна. СХД-ийн Тохижилт Цэвэрлэгээ Үйлчилгээний ОНӨААТҮГ-тэй хог хаягдал цуглуулах, тээвэрлэх гэрээг шинэчлэн байгуулан ажиллаж байна.</p>  <p align="center">ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙГ ХУРААХ, ТЭЭВЭРЛЭХ ГЭРЭЭ</p> <p align="center">НЭГ. ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО</p> <p>1.1 Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, төсвийг болон төрийн бус байгууллагуудын ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг цуглуулж ачих, тээвэрлэх, үйлчилгээний хураамжийг төвлөрүүлэхэд энэхүү гэрээний зорилго оршино.</p> <p align="center">ХОЁР. ГЭРЭЭНИЙ ҮНДСЭЛЭЛ</p> <p align="center">ДӨРӨВ. ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ЭРХ, ҮҮРЭГ</p> <p>4.1 Татварын хууль тогтоомжид заасны дагуу татварын байцаагч нь сар бүрийн 25-ны дотор гэрээнд заасан үнийн дүнгээр хог хаягдлын хураамжийг хураан авах эрхтэй.</p> <p>4.2 Гэрээнд зааснаар үйлчлүүлэгч нь гэрээний үүргийг биелүүлээгүй болон биелүүлэхээс татгалзсан үед...</p>	ХХТ хууль, НИТХ-ын 2013 оны “Хог тээврийн тариф батлах тухай” 12/45 тогтоол
2	Хог хаягдлыг эргүүлэн ашиглах		ХХТ хууль

		<p>Дахин ашиглах технологийн дагуу хаягдалгүй үйлдвэрлэл явагдаж үүний бүртгэлүүд хийгдсэн.</p>  <p>Зураг 3-45. Артишок эрүүл мэндийн ундаа олгосон, артишокны шилийг цуглуулж, тушаасан байдал</p>	
3	<p>Үйлдвэрийн талбайд ахуйн хогийн сав байршуулах</p>	<p>Мөн Артишок эрүүл мэндийн ундааны шилийг үйлдвэрлэгчид буцаанд тушааж, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, Recycle буюу эргүүлэн ашиглаж байна.</p> <p>Үйлдвэрийн талбайд ангилан ялгах ахуйн хогийн савнуудыг байрлуулсан.</p>  <p>Зураг 3-46. Агуулахад ангилдаг хогийн сав байрлуулсан байдал</p>	
6	<p>“Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт”-ын дагуу хог хаягдлын тоо бүртгэлээ тухай бүр хөтөлж, тогтоосон хугацаанд тайлагнах</p>	<p>Хог хаягдал ялгаруулаагүй тухай тайлан мэдээг улирал тутам харьяа дүүрэгт хүргүүлж ажилласан.</p>	<p>ХХТ хууль</p>

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Сика Монголиа” ХХК-ийн БЕТОН ЗУУРМАГИЙН НЭМЭЛТ БОДИС ИМПОРТЛОХ, АШИГЛАХ, ХАДГАЛАХ АГУУЛАХ төслийн 2024 оны БОМТ – БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

		<p align="center">  СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА ТАНАА СИКА МОНГОЛИА ХХК Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Үйлдэр /17043/, ХД-Т111/2 тоот Утас: 976 70131360 Факс: 976 70131360 Гар Утас: 88060467 2024 оны 10 сарын 07-ны № 630/2024 Төний _____-ны № _____-т 2024 оны III улирлын хог хаягдлын тайлан хүргүүлэх тухай “Сика Монголиа” ХХК /Улсын бүртгэлийн дугаар: 9019071038; Регистрийн дугаар: 5641683/ нь Швейцар улсын Sika AG компанийн 100 хувийн хөрөнгө оруулалттай компани бөгөөд 2012 оноос гадаад худалдаа, Sika® брэндийн барилгын материалын үйлдвэрлэл, худалдаа, техникийн зөвлөгөө өгөх чиглэлээр Монгол улсад үйл ажиллагаа явуулдаг. Сика Монголиа ХХК нь СХД-ийн 20-р хороо, Сонсгolon талбай-18132 гудамж, 27 тоотод байршилтай 624м2 талбай бүхий агуулахыг “Бетоны нэмэлтийн түүхий эд, бүтээгдэхүүний агуулах”-аар ашиглахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Тус агуулах дээр байнгын үйл ажиллагаа явуулж эхлээгүй байгаа тул 2024 оны III улиралд тайлагнах хог хаягдлын мэдээ байхгүйг мэдэгдэж байна. Зураг 3-48. Улирал тутамын хог хаягдлын тайлан хүргүүлсэн байдал / Хавсралт 13. 2024 оны 1-3 улирлын хог хаягдлын тайлан/ </p>	
<p>Нийт: 395,000.0 төгрөгийг хог хаягдлын менежментийн төлөвлөгөөт ажилд зарцуулсан байна.</p>			

3.7 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт 3-7 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөөний биелэлт

№	Хяналт шинжилгээний үзүүлэлтүүд	Биелэлт	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хөрс, усны шинжилгээ	Сика Монголиа ХХК нь 2024 оны 07 дугаар сард Сонсгolon агуулахын дотор орчны агаар, үйлдвэрлэлийн бүс дэхь хөрс, үйлдвэрийн болон ахуйн хэрэглээний уснаас дээж авч Хан-Уул дүүрэг дэх Цаг Уур, Орчны Шинжилгээний Газрын дэргэдэх Байгаль Орчин, Хэмжил Зүйн Төв Лабораторид шинжлүүлж, орчны хяналтыг тавьж ажилласан. Бүх техникийн үзүүлэлтүүд стандартын зөвшөөрөх хэмжээнд байв.	MNS 5850:2019
2	Агаарын чанарын шинжилгээ		MNS 4585:2016

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Сика Монголиа” ХХК-ийн БЕТОН ЗУУРМАГИЙН НЭМЭЛТ БОДИС ИМПОРТЛОХ, АШИГЛАХ, ХАДГАЛАХ АГУУЛАХ төслийн 2024 оны БОМТ – БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

	 <p>ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН ТӨВ ЛАБОРАТОРИ</p> <p>17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж, Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818 E-mail: bohrtf@gmail.com</p> 																																										
СОРИЛТЫН ДҮН																																											
Дугаар он/№ : 2024/A-265 Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : “Сика Монголиа” ХХК Сорьц авсан хүний нэр, албан тушаал : Д.Дөлгөөн агаарын хэсэг Сорьцын тоо, төрөл : 2 агаар, 2 дуу чимээ Сорьц авсан огноо : 2024.07.03 Сорьцын тодорхойлолт : Улаанбаатар хот СХД 20-р хороо Сонсголон 18132 гудамж 26 тоот Шинжилгээний аргын стандарт : MNS 17-2-5-12:2021, MNS 17-2-5-11:2021 MNS 5002:2000, САЗ А07-2016 Шинжилсэн огноо : 2024.10.07 Хуудасны тоо : 1/1 Үр дүн :																																											
<table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <thead> <tr> <th rowspan="2">№</th> <th rowspan="2">Сорьц авсан цэг</th> <th rowspan="2">Сорьц авсан өдөр</th> <th rowspan="2">Сорьц авсан цаг</th> <th rowspan="2">Хүхэрлэг хий мг/м³</th> <th rowspan="2">Азотын давхар исэл мг/м³</th> <th rowspan="2">Нийт тоос /TSP/ мг/м³</th> <th>Дуу чимээ</th> </tr> <tr> <th>ДБА</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Агуулах-1</td> <td>VIII/03</td> <td>12:20</td> <td>0.014</td> <td>0.030</td> <td>0.265</td> <td>61</td> </tr> <tr> <td>2</td> <td>Агуулах-2</td> <td>VIII/03</td> <td>12:40</td> <td>0.016</td> <td>0.029</td> <td>0.238</td> <td>66</td> </tr> <tr> <td colspan="7">Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2015</td> <td>2</td> </tr> <tr> <td colspan="7">Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, Шуугианы норм. Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS 5002:2000 (8 цагийн дундаж)</td> <td>85</td> </tr> </tbody> </table>			№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий мг/м ³	Азотын давхар исэл мг/м ³	Нийт тоос /TSP/ мг/м ³	Дуу чимээ	ДБА	1	Агуулах-1	VIII/03	12:20	0.014	0.030	0.265	61	2	Агуулах-2	VIII/03	12:40	0.016	0.029	0.238	66	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2015							2	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, Шуугианы норм. Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS 5002:2000 (8 цагийн дундаж)							85
№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр								Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий мг/м ³	Азотын давхар исэл мг/м ³	Нийт тоос /TSP/ мг/м ³	Дуу чимээ																													
			ДБА																																								
1	Агуулах-1	VIII/03	12:20	0.014	0.030	0.265	61																																				
2	Агуулах-2	VIII/03	12:40	0.016	0.029	0.238	66																																				
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2015							2																																				
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, Шуугианы норм. Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS 5002:2000 (8 цагийн дундаж)							85																																				
Шинжилгээ гүйцэтгэсэн шинжээч :  Э.Оюунтува Хянаж баталгаажуулсан: С.Отгонжаргал Байгаль орчны шинжилгээний ахлах шинжээч																																											
/Хавсралт 14. Агаар, ус, хөрсний шинжилгээний үр дүн, төлбөрийн баримт - 386,500.0 төгрөг/																																											
Нийт: 386,500.0 төгрөг																																											

Хүснэгт 3-8. Агаарын шинжилгээний дүн

№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Хүхэрлэг хий мг/м ³	Азотын давхар исэл мг/м ³	Нийт тоос мг/м ³	Дуу чимээ/ДБА
1	Агуулах дотор	2024 оны 07 сарын 03	0.014	0.030	0.265	61
2	Агуулах дотор	2024 оны 07 сарын 03	0.016	0.029	0.238	66
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2015					2	-
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Шуугианы норм. Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS 5002:2000						85

Хүснэгт 3-9. Гадна орчны хөрсний шинжилгээний үр дүн

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Сика Монголиа” ХХК-ийн БЕТОН ЗУУРМАГИЙН НЭМЭЛТ БОДИС ИМПОРТЛОХ, АШИГЛАХ, ХАДГАЛАХ АГУУЛАХ төслийн 2024 оны БОМТ – БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

№	Сорьц авсан цэг	Огноо	Чийг	pH	Ялзмаг, %	Аммоны азот (NH ₄ -N), мг/кг	Нитратын азот (NO ₃ -N), мг/кг	Фосфор (P ₂ O ₅), мг/кг	Сульфат (SO ₄), мг/кг
1	Агуулах хашаан дотор-1	2024.07.03	1.18	7.75	2.24	19.1	5.2	0.53	36.2
2	Агуулах хашаан дотор-2		1.64	7.26	2.50	20.7	2.0	0.45	26.1

Хүснэгт 3-10. Гадна орчны хөрсний шинжилгээний үр дүн-Хүнд металл

№	Сорьц авсан цэг	Огноо	Cd, мг/кг	Pb, мг/кг	Hg, мг/кг	Cr, мг/кг	Zn, мг/кг	Cu, мг/кг	Sr, мг/кг
1	Агуулах хашаан дотор-1	2024.07.03	0.7	17	<0.005	<0.5	26	28	814
2	Агуулах хашаан дотор-2		<0.5	14	<0.005	<0.5	18	28	553
MNS 5850:2019			3	100	2	150	300	100	800

Хүснэгт 3-10. Зөөврийн усны шинжилгээний үр дүн

№	Сорьц авсан цэг	Огноо	pH	ЕС мкС и/см	SO ₄ мг/л	Cl мг/л	Ca мг/л	Mg мг/л	Na+K мг/л	HCO ₃ мг/л	Эрд мг/л	Хат мг-экв/л
1	Хэрэглээний ус	2024/07/03	7.14	494	64.9	24.8	58.9	7.2	8.5	111	276	3.53

БОМТ-нд тусгасан болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь, баримтлах стандарт, аргачлал, зардлыг тодорхойлон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгав. ОХШХ нь байгаль орчин, нийгэм-эдийн засгийн үнэт зүйлсийг хамгаалах, түүнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа нь ямар үр дүнтэй байгааг илтгэх үндсэн баримт бичиг болно. Хяналт шинжилгээний дээж, сорьцыг МУ-ын болон гадаадын итгэмжлэгдсэн лабораториудад батлагдсан арга зүй, стандартын дагуу шинжлүүлнэ. Энэ хөтөлбөрийн хэрэгжилтийн асуудлыг төсөл хэрэгжүүлэгч тал бүрэн хариуцах тул мэргэжлийн хүн авч ажиллуулах эсвэл мэргэжлийн байгууллагатай гэрээлэн ажиллах хэрэгтэй. БОХТ-тэй холбогдон удирдамж болох үйлдвэр, агуулахын үйл ажиллагаанаас

байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг үнэлэн, “Сика Монголиа” ХХК-ий хэрэгжүүлэх ОХШХ боловсруулж гүйцэтгэсэн.

Агуулахын үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг илрүүлж, БОХТ хэрэгжилт, сөрөг нөлөөлөл хэмжээн дүнг хянаж шалгаж, цаашдын үйл ажиллагааг тодотгох зорилгоор хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт дотор орчны агаарын чанарын хяналт шинжилгээ хийх, хугацаа, давтамж, холбогдох стандарт зэргийг тодорхойлж, хяналт шинжилгээ хийхэд гарах зардлыг тооцон хийсэн. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт орчны агаарын, гадаргын хөрсний шинжилгээ хийхийг тусгасан бөгөөд шаардлагатай шинжилгээнүүдийг Хан-Уул дүүрэг дэх Цаг уур, орчны шинжилгээний газар байгаль орчин хэмжил зүйн төв лабораториор шинжлүүлсэн.



Зураг 3-49. Орчны шинжилгээний лабораторийн үр дүн

3.8 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 3-11 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Биелэлтийн тайлан	Тайлбар
1	SMS (Сика менежмент систем)-ын сайжруулалтыг ISO 9001 болон ISO 45001 нэвтрүүлэлтийн хэмжээнд тогтмол хийх, цаашид ISO 14001 болон ISO5001 хэрэгжүүлэх суурь судалгаа болон сургалтыг эхлүүлэх	Сика Монголиа ХХК нь 2023 онд нэгдсэн менежментийн тогтолцооны ISO 9001 болон ISO 45001 стандартын дотоод аудиторроор 9 хүн бэлтгэсэн бөгөөд ISO 9001 болон ISO 45001 стандартын магадлан итгэмжлэлд амжилттай орж, 2026 он хүртэл сунгуулж чадсан. /Хавсралт 16. ISO 9001/45001 стандартын итгэмжлэлийн гэрчилгээ /	ISO 9001; ISO 45001
	Нийт:	төгрөгийг удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөт ажилд зарцуулсан байна.	


3.9 Нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах хөтөлбөр

Хүснэгт 3-12. Нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах хөтөлбөрийн биелэлт

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Тайлбар
1	БОАЖЯ	Тайлан	БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу	Холбогдох газруудад БОМТ биелэлтийн тайланг тайлагнахаар ажиллаж байна.
2	Сонгино хайрхан дүүргийн ЗДТГ	Тайлан Хэлэлцүүлэг Газар дээрх үзлэг		
3	Нийслэлийн орчны газар байгаль	Тайлан Хэлэлцүүлэг Газар дээрх үзлэг		

3.10 2022 онд хийгдсэн Байгаль Орчны Аудитын зөвлөмжид тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө

Хүснэгт 3-13. Байгаль орчны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлт

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Биелэлт
1	3 тасалгаат хогийн савыг байрлуулах	<p>Тус тайлангийн 3.6.3-т дурьдсаны дагуу үйлдвэр, агуулахын талбайд ангилан ялгах ахуйн хогийн савнуудыг байрлуулсан.</p>  <p>Зураг 3-52. Үйлдвэр, агуулахад ангилдаг хогийн сав байрлуулсан байдал</p>

2	<p>Байгалийн болон хүний хүчин зүйл техникийн гаралтай гамшгийн төрөл тус бүрээр эрсдэлийн үнэлгээ дахин хийж, сайжруулах ба эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах, төлөвлөгөөг шинэчлэх, байгалийн гамшиг, үйлдвэр, тээврийн ослын үед гарч болзошгүй химийн хорт бодисын алдагдлаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг нь арилгах замаар амьдрах орчны аюулгүй байдлыг хангах байдлыг нэмэгдүүлэх, сайжруулах.</p>	<p>Тус тайлангийн 3.8.5-д дурьдсаны дагуу үйлдвэрийн байршил өөрчлөгдөх, Сонсголон-агуулахын байршилд БОННҮТ батлагдсаны дараа гамшгийн эрсдэлийн үнэлгээг хийлгэхээр төлөвлөж байна.</p>
3	<p>Химийн хорт болон аюултай бодисыг техникийн болон аюулгүйн шаардлага хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэж буйг бататгах бөгөөд уг тээврийн хэрэгсэлд анхааруулах тэмдэг, аюулын шинж чанарын тухай санамж байрлуулж, тээвэрлэлт, ачилтын явцыг баталгаажуулах, зааварчилгаа өгөх хэлбэр, нотолгоо баримтжуулалтыг сайжруулах.</p>	<p>Сика Монголиа ХХК нь Олон улсын тээвэр зуучийн үйлчилгээг “Омни Шиппинг” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу авдаг. Монгол улс доторх дотоодын тээврийг “Сийлон” ХХК-иар дамжуулан авдаг.</p> <p>Сийлон ХХК нь химийн бодисын ачаа тээвэрлэхдээ бүх ажилчиддаа ХАБЭА-ийн бодлого, Эрсдэлийн Удирдлагын Тогтолцооны журам, Ослын Мэдээллэх, Судлан Бүртгэх Журамыг танилцуулдаг.</p> <p>/ Хавсралт 18. Сийлон ХХК-ийн ХАБЭА бодлого, Эрсдэлийн Удирдлагын Тогтолцооны журам, Ослын Мэдээллэх, Судлан Бүртгэх Журам /</p> <p>Мөн Сийлон ХХК нь тээврийн хэрэгслүүд дээрээ химийн бодисын анхааруулах тэмдэг, тэмдэглэгээг бүрэн байршуулсан, аюултай ачааг тээвэрлэхдээ жолоочид аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч, осол, химийн бодисын асаралт болсон тохиолдолд авах арга хэмжээний төлөвлөгөөг тогтмол танилцуулдаг.</p>



		Зураг 3-53. Тээврийн хэрэгсэл дээрх химийн бодисын таних тэмдэг, аюулын зэрэг, асгаралтын үеийн иж бүрдэл байршуулсан байдал															
4	Тээвэрлэгч байгууллагатай гэрээ байгуулахдаа тухайн бодисын монгол хэл дээрх хор, аюулгүй байдлын лавлах мэдээлэл, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, болзошгүй ослын үед ажиллах төлөвлөгөө, тээвэрлэх маршрут зэргийг танилцуулж гарын үсэг зуруулах ба дотоод журамд заасан хугацаанд хадгалах.	<p>Сика Монголиа ХХК нь химийн бодисын түүхий эд, бэлэн бүтээгдэхүүний Хор Аюулын Лавлах Мэдээлэл буюу MSDS-ийг англи, монгол хэл дээр бэлтгэсэн байдаг. Цаасны ашиглалт, түүнээс гарах хог хаягдалын хэмжээг бууруулах үүднээс бүх MSDS-ийг QR-based болгож байна. Тээвэрлүүлэхийн өмнө бүтээгдэхүүний бүх мэдээллийг тээврийн компанид өгч, танилцуулдаг.</p> <table border="1"> <tr> <td>Sika ViscoCrete WR-14</td> <td>Eng</td> <td>https://sikachina.mn/hulu.net/7/aBQCh</td> <td></td> </tr> <tr> <td>Sika ViscoCrete SK-67</td> <td>Mon</td> <td>https://sikachina.mn/hulu.net/7/hjllam</td> <td></td> </tr> <tr> <td rowspan="2">Sika ViscoCrete WR-9</td> <td>Eng</td> <td>https://sikachina.mn/hulu.net/7/cW5o0</td> <td></td> </tr> <tr> <td>Mon</td> <td>https://sikachina.mn/hulu.net/7/cWdM7y</td> <td></td> </tr> </table>	Sika ViscoCrete WR-14	Eng	https://sikachina.mn/hulu.net/7/aBQCh		Sika ViscoCrete SK-67	Mon	https://sikachina.mn/hulu.net/7/hjllam		Sika ViscoCrete WR-9	Eng	https://sikachina.mn/hulu.net/7/cW5o0		Mon	https://sikachina.mn/hulu.net/7/cWdM7y	
Sika ViscoCrete WR-14	Eng	https://sikachina.mn/hulu.net/7/aBQCh															
Sika ViscoCrete SK-67	Mon	https://sikachina.mn/hulu.net/7/hjllam															
Sika ViscoCrete WR-9	Eng	https://sikachina.mn/hulu.net/7/cW5o0															
	Mon	https://sikachina.mn/hulu.net/7/cWdM7y															
5	2022 онуудын аудитын үр дүнг-ээс гарсан зөвлөмж, Гамшгийн эрсдэлийн үнэлгээнээс гарсан зөвлөмж, Химийн ослын эрсдэлийн үнэлгээнээс гарсан зөвлөмжийг тус тус үндэслэн тусгайлсан эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг баримтжуулах.	3.8.5-д дурьдсаны дагуу хүлээгдэж байна.															

4 ДҮГНЭЛТ

Ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдал болон байгаль орчин хамгаалал, үйл ажиллагаагаа явуулж буй улс орнуудын хууль дүрмийг бүрэн дүүрэн дагаж мөрдөх нь тус компанийн үүрэг болохыг “Сика Монголиа” ХХК-ийн гүйцэтгэх захирал тодорхой дурдсан, Товчоор хэлбэл Хор хөнөөлгүй байх гэж болно. Менежментийн системийн хувьд, дээрх үүргээ ухамсарлан биелүүлэх эх суурийг бий болгож, тасралтгүй сайжруулж байх зорилготой.

Бид байгаль орчны хамгаалах тухай хууль тогтоомж, 2018 онд батлагдсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тодорхойлсон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга

хэмжээний зөвлөмж, 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын хэрэгжилтийн биелэлтэд бидний үйл ажиллагаанаас үүдэн байгаль орчинд учирч болох сөрөг нөлөөнөөс урьдчилан сэргийлэх, орон нутгийн байгаль орчны хамгаалалд хувь нэмрээ оруулах тал дээр түлхүү анхаарч ажилласан болно.

Тогтвортой хэрэглээ ба үйлдвэрлэл хүрээнд ногоон эдийн засгийг дэмжих, улс орныхоо нүүрстөрөгч багатай, үр ашигтай, хаягдалгүй эдийн засагт шилжихэд өөрсдийн хувь нэмэр ээ оруулах зорилгоор оролцож буй төсөл хөтөлбөр, явуулж буй үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг багасгах, дахин ашиглах, үйлдвэрлэлдээ хаягдалгүй технологи нэвтрүүлэн ажиллаж байна. Мөн Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран олон нийт, хэрэглэгч, үйлдвэрлэгч нарт чиглэсэн техникийн зөвлөгөө, сургалт, сайн туршлагаас харилцан суралцах боломж олгох, мэдлэг түгээх хөтөлбөрүүдэд идэвх, санаачлагатай оролцож ирсэн. Тухайлбал эрчим хүч, нөөцийн үр ашигтай, уур амьсгал, агаарын бохирдол хамгаалах, эдийн засгийн үр ашигтай, цементийн нэмэлтийн технологийн талаарх танилцуулга, өдөрлөг хийсэн нь хүлэмжийн хийн ялгарал багатай, тогтвортой барилга бий болгоход дэмжлэг үзүүлэх барилгын материал бий болгох боломж буйг үйлдвэрлэгч нарт таниулсан. "Бидний үйлдвэрлэж буй бетон хольцын химийн нэмэлт нь бетоны CO2 ялгаруулалтыг хоёр дахин бууруулдаг. Энэ нь байгалийн нөөцийг хамгаалахад чухал хувь нэмэр оруулдаг." БОМТ хэрэгжилтэд дотоод удирдлага, зохион байгуулалтаас гадна, байгаль орчны мэргэжилтэн, олон нийтийн санал, зөвлөгөө, аудитын зөвлөмж чухал нөлөө үзүүлсэн.

Цаашид Sika® групп компани нь 2028 он хүртэлх Бизнесийн болон Тогтвортой хөгжлийн зорилтоо 2023 онд баталсан бөгөөд үүний хүрээнд түлш, эрчим хүчний ашиглалтаас ялгаруулах хүлэмжийн хийн хэмжээг одоо байгаа түвшинөөс 20% багасгах, хог хаягдал болон усны зарцуулалтыг 15% багасгаж илүү байгальд ээлтэй, усны орцыг багасгах технологийг хөгжүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдлыг чухалчлан ЛТА буюу хугацаа алдсан ослын тоог 1000 хүн тутамд 2-оос бага (< 2 per 1000 FTE) түвшинд хүргэх зорилт тавьсан.





Зураг 4-1. Sika® группийн “Илүү үнэ цэнэ – Бага нөлөөлөл” тогтвортой хөгжлийн бодлого

5 ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

Хавсралт 1. Сика Монголиа ХХК-ийн 2023 оын III улирлын Тогтвортой хөгжлийн мэдээ (MIS report)

Хавсралт 2. Нунтаг түүхий эдийн тэжээх төхөөрөмж (Hopper machine), сорох системийн ажлын төлбөр – 47,277,021.29 төгрөг

Хавсралт 3. Хурдны хязгаарын тэмдэг худалдан авсан баримт – 319,000 төгрөг

Хавсралт 4. 2023-ын аюултай хог хаягдалын устгалтын нэхэмжлэх, дагалдах бичиг – 11,885,500 төгрөг

Хавсралт 5. Зүлэг худалдан авсан болон мод худалдан авсан баримт - 498,850 төгрөг

Хавсралт 6. Химийн бодисын аюулгүй ажиллагааны сургалтын гэрчилгээ

Хавсралт 7. Артишок олгосон худалдан авалтын баримт

Хавсралт 8. ХАБЭА-ийн тэмдэг, тэмдэглэгээ худалдан авсан баримт - 2,178,550 төгрөг

Хавсралт 9. Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний гэрээ, ажлын байрны жагсаалт

- Хавсралт 10. Галын хор худалдан авсан төлбөрийн баримт – 2,200,000 төгрөг
Хавсралт 11. Хогны гэрээ, Хог ачилтын хуудас
Хавсралт 12. Ахуйн ангилдаг хогийн сав худалдан авсан баримт - 395,000 төгрөг
Хавсралт 13. 2023 оны 1-3 улирлын хог хаягдлын тайлан
Хавсралт 14. Агаар, ус, хөрсний шинжилгээний үр дүн, төлбөрийн баримт - 264,900.0 төгрөг
Хавсралт 15. Ажилчдын эрүүл мэндийн үзлэг, Бодь Эрүүл Мэндийн Даатгалын төлбөрийн баримт - 32,102,191.49 төгрөг
Хавсралт 16. ISO 9001/45001 стандартын итгэмжлэлийн гэрчилгээ
Хавсралт 17. БОННҮТ боловсруулах ажлын төлбөрийн нэхэмжлэх, төлбөр шилжүүлсэн баримт – 2,000,000 төгрөг
Хавсралт 18. Сийлон ХХК-ийн ХАБЭА бодлого, Эрсдэлийн Удирдлагын Тогтолцооны журам, Ослын Мэдээллэх, Судлан Бүртгэх Журам

"Сика Монголиа"ХХК

Холбоо барих

СБД, 1-хороо
Ландмарк Тауэр,
502 тоот

Утас +976 70131360
Fax +976 70131360
www.mng.sika.com

BUILDING TRUST

